



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/95/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа

Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар

Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn

Аудитор: Ж.Мөнгөншагай

Утас: 90909190

Цахим хаяг: Mungunshagai.J@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга	
1.Аудитын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	21
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ХАЙРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

2022.02.25 № 137
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хайрхан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хайрхан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	77,199,692.00	51,428,862.00
2	АВЛАГА	1,126,920.00	0.00
3	Бусад авлага	1,126,920.00	0.00
4	Хувь хүмүүсээс авах авлага	1,126,920.00	0.00
5	БАРАА МАТЕРИАЛ	76,072,772.00	51,428,862.00
6	Түүхий эд материал	0.00	1,950,500.00
7	Эм боох материал	0.00	1,950,500.00
8	Хангамжийн материал	62,711,772.00	37,632,362.00
9	Бичиг хэргийн материал	1,921,875.00	1,839,275.00
10	Аж ахуйн материал	8,703,029.00	7,099,879.00
11	Сэлбэг хэрэгсэл	2,635,108.00	15,108.00
12	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
13	Барилгын засварын материал	973,100.00	973,100.00
14	Бусад хангамжийн материал	48,478,660.00	27,705,000.00
15	Мал амьтад	13,361,000.00	11,846,000.00
16	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,862,142,740.59	2,009,048,161.68
17	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,862,142,740.59	2,009,048,161.68
18	Биет хөрөнгө	1,845,462,740.59	1,992,368,161.68
19	Барилга, байгууламж, орон сууц	875,810,800.14	875,810,800.14
20	Хуримтлагдсан элэгдэл	-39,712,309.05	-58,986,275.55
21	Авто-тээврийн хэрэгсэл	117,844,800.00	97,344,800.00
22	Хуримтлагдсан элэгдэл	-73,121,038.58	-57,035,188.86
23	Машин тоног төхөөрөмж(компьютер)	268,824,616.14	255,781,616.34
24	Хуримтлагдсан элэгдэл	-135,339,658.99	-145,620,699.13
25	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,508,777.27	79,937,599.00
26	Хуримтлагдсан элэгдэл	-44,506,199.50	-47,857,042.13
27	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20,847,200.00	20,847,200.00
28	Бусад үндсэн хөрөнгө	1,210,935,604.00	1,403,706,025.00
29	Хуримтлагдсан элэгдэл	-430,629,850.84	-469,666,273.13
30	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	38,105,600.00

31	Биет бус хөрөнгө	16,680,000.00	16,680,000.00
32	Програм хангамж	5,500,000.00	5,500,000.00
33	Бусад биет бус хөрөнгө	11,180,000.00	11,180,000.00
34	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,939,342,432.59	2,060,477,023.68
35	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,360.00	0.00
36	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,360.00	0.00
37	Өглөг	9,360.00	0.00
38	Бусад өглөг	9,360.00	0.00
39	Байгууллагад төлөх өглөг	9,360.00	0.00
40	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,939,333,072.59	2,060,477,023.68
41	Засгийн газрын хувь оролцоо	1,939,333,072.59	2,060,477,023.68
42	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,116,428.17	448,116,428.17
43	Хуримтлагдсан үр дүн	945,101,190.87	1,066,245,141.96
44	Өмнөх үеийн үр дүн	945,101,190.87	945,101,190.87
45	Тайлант үеийн үр дүн		121,143,951.09
46	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	546,115,453.55	546,115,453.55
47	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,939,342,432.59	2,060,477,023.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	735,137,622.00	726,551,892.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	204,535,345.00	209,792,279.00
3	Нийтлэг татварын бус орлого	204,535,345.00	187,884,279.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	204,535,345.00	3,018,000.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,499,000.00	3,018,000.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	201,036,345.00	0.00
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	171,565,279.00
8	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	13,301,000.00

9	Тусламжийн орлого	0.00	21,908,000.00
10	Хандив тусламж /дотоод/	0.00	21,908,000.00
11	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	530,602,277.00	516,759,613.00
12	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,728,677.00	58,635,413.00
13	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,514,000.00	17,098,940.00
14	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,214,677.00	41,536,473.00
15	Орон нутгийн төсвөөс санхүүжих	482,873,600.00	458,124,200.00
16	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	482,873,600.00	458,124,200.00
17	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	573,650,849.81	605,407,940.91
18	УРСГАЛ ЗАРДАЛ	573,650,849.81	605,407,940.91
19	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	548,985,451.81	589,281,554.91
20	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,325,873.00	227,235,850.00
21	Үндсэн цалин	218,325,873.00	227,235,850.00
22	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,250,261.00	29,553,699.00
23	Тэтгэврийн даатгал	19,437,544.65	20,478,191.00
24	Тэтгэмжийн даатгал	2,283,478.73	2,276,550.00
25	ҮОМШӨ-ний даатгал	1,745,115.15	1,816,955.00
26	Ажилгүйдлийн даатгал	421,334.57	439,610.00
27	Эрүүл мэндийн даатгал	4,362,787.90	4,542,393.00
28	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,852,850.00	90,686,896.00
29	Гэрэл, цахилгаан	3,853,150.00	3,784,458.00
30	Түлш, халаалт	86,799,700.00	86,797,096.00
31	Цэвэр, бохир ус	200,000.00	105,342.00
32	Хангамж, бараа материалын зардал	45,533,921.00	33,123,040.00
33	Бичиг хэрэг	2,869,000.00	3,382,600.00
34	Тээвэр, шатахуун	23,255,221.00	16,113,980.00
35	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,604,700.00	2,606,000.00
36	Ном, хэвлэл	257,200.00	216,000.00

37	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,024,000.00	5,929,910.00
38	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,823,800.00	1,772,400.00
39	Бараа материал акталсны зардал	4,700,000.00	3,102,150.00
40	Нормативт зардал	0.00	660,000.00
41	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	660,000.00
42	Эд хогшил, урсгал засварын зардал	4,647,500.00	2,620,000.00
43	Урсгал засвар	4,647,500.00	2,620,000.00
44	Томилолт, зочны зардал	2,012,800.00	1,488,000.00
45	Дотоод албан томилолт	2,012,800.00	1,488,000.00
46	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,827,034.00	4,141,747.00
47	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,755,312.00	3,109,213.00
48	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
49	Даатгалын үйлчилгээ	190,000.00	184,634.00
50	Тээврийн хэрэгслийн татвар	72,354.00	88,000.00
51	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	55,000.00
52	Газрын төлбөр	187,368.00	104,900.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	149,535,212.81	199,772,322.91
54	Бараа үйлчилгээний бусад зардал	51,127,010.00	108,603,865.00
55	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,408,202.81	91,168,457.91
56	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,665,398.00	16,126,386.00
57	Бусад урсгал шилжүүлэг	940,000.00	1,440,000.00
58	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	940,000.00	1,440,000.00
59	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,725,398.00	14,686,386.00
60	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,915,398.00	5,614,981.00
61	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,810,000.00	9,071,405.00
62	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	161,486,772.19	121,143,951.09
63	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	161,486,772.19	121,143,951.09

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /
төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,116,428.17	546,115,453.55	945,101,190.87	1,939,333,072.59
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,116,428.17	546,115,453.55	945,101,190.87	1,939,333,072.59
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	121,143,951.09	121,143,951.09
4	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	448,116,428.17	546,115,453.55	1,066,245,141.96	2,060,477,023.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /

/ төгрөгөөр

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	534,101,277.00	542,812,533.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,499,000.00	4,144,920.00
3	Нийтлэг татварын бус орлого	3,499,000.00	4,144,920.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499,000.00	4,144,920.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,499,000.00	4,144,920.00
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	530,602,277.00	538,667,613.00
7	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,728,677.00	80,543,413.00
8	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,514,000.00	21,908,000.00
9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,214,677.00	41,536,473.00
10	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	17,098,940.00
11	Орон нутгийн төсвөөс санхүүжих	482,873,600.00	458,124,200.00
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	482,873,600.00	458,124,200.00
13	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	477,790,677.00	476,303,933.00
14	УРСГАЛ ЗАРДАЛ	477,790,677.00	476,303,933.00
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,125,279.00	460,177,547.00

16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,989,508.00	227,245,210.00
17	Үндсэн цалин	211,989,508.00	227,245,210.00
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,973,719.00	29,553,699.00
19	Тэтгэврийн даатгал	18,526,411.00	20,478,191.00
20	Тэтгэмжийн даатгал	2,159,106.00	2,276,550.00
21	ҮОМШӨ-ний даатгал	1,679,212.00	1,816,955.00
22	Ажилгүйдлийн даатгал	410,964.00	439,610.00
23	Эрүүл мэндийн даатгал	4,198,026.00	4,542,393.00
24	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,999,700.00	90,686,896.00
25	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	3,784,458.00
26	Түлш, халаалт	86,799,700.00	86,797,096.00
27	Цэвэр, бохир ус	200,000.00	105,342.00
28	Хангамж, бараа материалын зардал	38,378,217.00	29,838,290.00
29	Бичиг хэрэг	3,299,600.00	3,195,000.00
30	Тээвэр, шатахуун	22,092,717.00	16,113,980.00
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,604,700.00	2,606,000.00
32	Ном, хэвлэл	257,200.00	321,000.00
33	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,024,000.00	5,929,910.00
34	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.00	1,672,400.00
35	Нормативт зардал	800,000.00	1,119,000.00
36	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	1,119,000.00
37	Эд хогшил, урсгал засварын зардал	4,425,000.00	0.00
38	Багаж, техник, хэрэгсэл	425,000.00	0.00
39	Урсгал засвар	4,000,000.00	0.00
40	Томилолт, зочны зардал	2,012,800.00	1,488,000.00
41	Дотоод албан томилолт	2,012,800.00	1,488,000.00
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,231,685.00	4,141,747.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,159,963.00	3,109,213.00
44	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
45	Даатгалын үйлчилгээ	190,000.00	184,634.00
46	Тээврийн хэрэгслийн татвар	72,354.00	88,000.00
47	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	55,000.00

48	Газрын төлбөр	187,368.00	104,900.00
49	Бараа үйлчилгээний бусад зардал	58,314,650.00	76,104,705.00
50	Бараа үйлчилгээний бусад зардал	58,314,650.00	76,104,705.00
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,665,398.00	16,126,386.00
52	Бусад урсгал шилжүүлэг	940,000.00	1,440,000.00
53	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	940,000.00	1,440,000.00
54	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,725,398.00	14,686,386.00
55	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,915,398.00	5,614,981.00
56	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,810,000.00	9,071,405.00
57	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	56,310,600.00	66,508,600.00
58	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	56,310,600.00	66,508,600.00
59	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,310,600.00	66,508,600.00
60	Дотоод эх үүсвэрээр	56,310,600.00	66,508,600.00
61	Барилга байгууламж	2,203,560.00	0.00
62	Бусад хөрөнгө	4,000,000.00	0.00
63	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,107,040.00	66,508,600.00
64	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-56,310,600.00	-66,508,600.00
65	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
66	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /
төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	495,994,700.00	456,654,139.00	39,340,561.00	92.07
2	УРСГАЛ ЗАРДАЛ	447,889,100.00	408,548,539.00	39,340,561.00	91.22
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,389,100.00	407,108,539.00	39,280,561.00	91.20
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,684,200.00	227,245,210.00	2,438,990.00	98.94
5	Үндсэн цалин	229,684,200.00	227,245,210.00	2,438,990.00	98.94
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,007,300.00	29,553,699.00	1,453,601.00	95.31

Хайрхан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

7	Тэтгэврийн даатгал	21,820,000.00	20,478,191.00	1,341,809.00	93.85
8	Тэтгэмжийн даатгал	2,296,700.00	2,276,550.00	20,150.00	99.12
9	ҮОМШӨ-ний даатгал	1,837,500.00	1,816,955.00	20,545.00	98.88
10	Ажилгүйдлийн даатгал	459,400.00	439,610.00	19,790.00	95.69
11	Эрүүл мэндийн даатгал	4,593,700.00	4,542,393.00	51,307.00	98.88
12	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,000,000.00	90,686,896.00	313,104.00	99.66
13	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	3,784,458.00	215,542.00	94.61
14	Түлш, халаалт	86,800,000.00	86,797,096.00	2,904.00	100.00
15	Цэвэр, бохир ус	200,000.00	105,342.00	94,658.00	52.67
16	Хангамж, бараа материалын зардал	38,413,600.00	29,703,250.00	8,710,350.00	77.32
17	Бичиг хэрэг	3,300,000.00	3,195,000.00	105,000.00	96.82
18	Тээвэр, шатахуун	21,600,000.00	15,978,940.00	5,621,060.00	73.98
19	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,613,600.00	2,606,000.00	7,600	99.71
20	Ном, хэвлэл	400,000.00	321,000.00	79,000.00	80.25
21	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,500,000.00	5,929,910.00	2,570,090.00	69.76
22	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,672,400.00	327,600.00	83.62
23	Нормативт зардал	1,129,100.00	1,119,000.00	10,100	99.11
24	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,129,100.00	1,119,000.00	10,100.00	99.11
25	Томилолт, зочны зардал	3,700,000.00	1,488,000.00	2,212,000.00	40.22
26	Дотоод албан томилолт	3,700,000.00	1,488,000.00	2,212,000.00	40.22
27	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,154,900.00	3,032,534.00	122,366.00	96.12
28	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
29	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	600,000.00	4,800	99.21
30	Даатгалын үйлчилгээ	190,000.00	184,634.00	5,366.00	97.18
31	Тээврийн хэрэгслийн татвар	88,000.00	88,000.00	0.00	100.00
32	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	0.00	100.00

Хайрхан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

33	Газрын төлбөр	217,100.00	104,900.00	122,200.00	48.32
34	Бараа үйлчилгээний бусад зардал	48,300,000.00	24,279,950.00	24,020,050.00	50.27
35	Бараа үйлчилгээний бусад зардал	48,000,000.00	24,279,950.00	23,720,050.00	50.58
36	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	0.00	300,000.00	
37	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,440,000.00	60,000.00	96.00
38	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,440,000.00	60,000.00	96.00
39	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,440,000.00	60,000.00	96.00
40	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,105,600.00	48,105,600.00	0.00	100.00
41	Бусад хөрөнгө	48,105,600.00	48,105,600.00	0.00	100.00
42	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	495,994,700.00	456,654,139.00	39,340,561.00	92.07
43	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	493,494,700.00	452,509,219.00	40,985,481.00	91.69
44	Орон нутгийн төсвөөс	493,494,700.00	452,509,219.00	40,985,481.00	91.69
45	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,500,000.00	4,144,920.00	-1,644,920.00	165.80
46	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	4,144,920.00	-1,644,920.00	165.80
47	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.00	0.00	0.00	100.00
48	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
49	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
50	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	0.00	100.00
51	Удирдах ажилтан	3.00	3.00	0.00	100.00
52	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	0.00	100.00
53	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.00
54	Гэрээт ажилтан	4.00	4.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,472,008.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	66,472,008.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,472,008.00
4	Хангамж, бараа материалын зардал	135,040.00
5	Бичиг хэрэг	
6	Тээвэр, шатахуун	135,040.00
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,109,213.00
12	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,109,213.00
13	Бараа үйлчилгээний бусад зардал	65,227,755.00
14	Бараа үйлчилгээний бусад зардал	65,227,755.00
15	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00
16	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00
17	Бусад хөрөнгө	5,000,000.00
18	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,472,008.00
19	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,543,413.00
20	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,908,000.00
21	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,536,473.00
22	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,098,940.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хайрхан сумын ЗДТГ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, мэдээлэлийг хуулинд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайрхан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21 -ны өдрийн 03/35 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хайрхан сумын ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-д “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах”, 67.1.2-д “Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах”, 67.1.3-д “Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Төрийн байгууллага болон төрийн албан хаагчдыг манлайлах үр чадвартай, иргэдэд шуурхай үйлчилдэг цомхон чадварлаг төрийн алба бүрдүүлж, хөгжлийн үзүүлэлтээрээ аймгийн зүүн бүсийн сумдын төв болох”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжгүй тул үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайрхан сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 495.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 121.1 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Авлага	1.1	-	(1.1)	-100.0
Бараа материал	76.1	51.5	(24.6)	-32.4
Үндсэн хөрөнгө	1,862.1	2,009.0	146.9	7.9
Нийт хөрөнгө	1,939.3	2,060.4	121.1	6.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,939.3	2,060.4	121.1	6.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,939.3	2,060.4	121.1	6.2

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлт байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 100 буурсан байна.

Авлагын данс нь 1.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд авлага 1.1 сая төгрөгөөр буурсан байна.

- Бараа материалын үлдэгдэл 35.4 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 76.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 79.3 сая төгрөг, хандиваар буюу үнэ төлбөргүй хүлээн авсан 13.3 сая төгрөг нийт 92.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 117.3 сая төгрөгийн зарцуулалт гарч, 51.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 7.9 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,862.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 66.5 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 171.6 сая төгрөг нийт 238.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд байгуулсан 91.2 сая төгрөгийн элэгдэл нийт 126.5 сая төгрөгөөр буурч оны эцэст 2,009.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 121.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	482.8	458.1	(24.7)
Нэмэлт санхүүжилтийн орлого	47.7	80.5	32.8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	201.0	-	(201.0)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	171.5	171.5
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	13.3	13.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	3.4	3.0	(0.4)
Үйл ажиллагааны орлого	734.9	726.4	(8.5)
Цалин, шимтгэлийн зардал	238.8	256.7	17.9
Бусад бараа үйлчилгээний зардал	310.2	332.6	22.4
Урсгал шилжүүлэг	24.6	16.1	(8.5)
Үйл ажиллагааны зардал	573.6	605.4	31.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	161.3	121.0	(40.3)

Хайрхан сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлого 32.8 сая төгрөгөөр өссөн тайлант онд ковид-19 цар тахлын үед халдвар хамгаалалын түвшинд зарцуулалт гарсантай холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 550.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 125.2 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 424.9 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 14.3 хувиар буюу 71.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ. Төсөв нэмэгдүүлсэн шалтгаан нь ковид 19 цар тахал, өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотой нэмэгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 495.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг 458.1 сая төгрөгөөр авч, 456.6 сая төгрөгийн буюу 92.1 хувийн зарцуулалт хийсэн байна. Тайлангийн жилд сумын Орон нутгийн төсвийн орлогын гүйцтгэл дутуугаас 35.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 80.5 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын нөөц сангаас 26.1 сая төгрөгийн санхүүжилт ирснийг сумын Засаг даргын захирамжаар ковид 19 цар тахлын тусгаарлах байрны хоол, хүнс, шатахуун, бусад зардалд, мөн цэрэг татлагын шатахуун, шүлхий өвчний шатахуун, бусад зардалд зарцуулсан
- Аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогод 1.1 сая төгрөг, Ар-Ус Ундарга ХХК-аас усны төлбөрт 13.4 сая төгрөг, Ар.Хамтарсан багаас 0.8 сая төгрөг, нийт 15.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч сумын Засаг даргын захирамж шийдвэрийн дагуу зарцуулсан байна.
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгжүүдээс ковид 19 цар тахалтай холбоотой 21.9 сая төгрөгийн хандивын орлого төвлөрснийг сумын Засаг даргын захирамжийн дагуу тусгаарлах байрны хоол, хүнс, аж ахуйн материал болон шатахууны зардалд 18.2 сая төгрөг зарцуулсан

- Өвс тэжээл борлуулсан орлого 17.1 сая төгрөг орсон бол 11.6 сая төгрөгийн өвс тэжээлд тус тус зарцуулан 9.1 сая төгрөгийн хэмнэлт үүсгэн дээд шатны төсөв захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангах зорилгоор сумын фондны өвс тэжээл бэлтгэх зардлаас 11.6 сая төгрөгийн 1670 боодол ногоон тэжээл бэтгэсэн байна.

Гоц халдварт буюу шүлхий өвчний зардалд 10.8 сая төгрөг зарцуулсан, сумын ИТХуралд 20.5 сая төгрөгийн авто машиныг шилжүүлсэн байна.

Мөн тайлант онд Тамгын газрын дарга Б.Мөнхдэлгэр нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4-т заасны дагуу өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн тул сумын Засаг даргын б/25 тоот захирамжаар даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр М.Оюунцэцэгийг 2021.10.25-ны өдрөөс томилон ажиллуулж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 1 үндсэн зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 84.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 495.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 92.1 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин, албан конторын тавилга, албаны болон дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан аваагүй байна.
2. Байгууллагын дарга нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4-т заасны дагуу албан ажлаас чөлөөлөгдсөн тул даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч шинээр томилогдон 2.1 сая төгрөгийн цалин олгосон нь зайлшгүй шаардлагатай албан тушаалын томилгоо хийсэн байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: Байгууллага нь өөрийн данс бүртгэлд 2 авто машинтай бөгөөд шатахууны зардалд 15.9 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 7.6 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах

зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

Хайрхан сумын ЗДТГ нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 19 мэдээллийг хугацаа хоцроож, 306.8 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хайрхан сумын ЗДТГ нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 19 мэдээллийг хугацаа хоцроож, 306.8 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: *Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөө.*

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10 хувийн хэмнэлтийг бий болгосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилты холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар УСНББОУС болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулахад анхаарч ажиллах, Сангийн сайдын 2018 оны 318 тоот тогтоолоор баталсан Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт зарцуулалтын нийтлэг журмыг дагаж мөрдөн ажиллах зөвлөмжүүдийг хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хөрөнгө, бараа материалын дансыг авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 65.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 3 заалт бүхий зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Тус байгууллагын 2021 оны үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтын дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 5 нэр төрлийн 47.1 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тухайн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд 29 нэр төрлийн 18.3 сая төгрөгийн бараа материалын шинжтэй хөрөнгө бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Тухайн бараа материалудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох хууль, журмын дагуу бүртгэл тайланд залруулан үнэн зөв бүртгэх арга хэмжээ авч ажиллах

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал														
1	Хайрхан сумын ЗДТГ	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 5 нэр төрлийн 47.2 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл байгаа нь ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	47.2							1	47.2		
2		Тус байгууллага нь 2021 оны байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.	1								1			
3		Үндсэн хөрөнгийн дансанд 29 нэр төрлийн 18.3 сая төгрөгийн бараа материалын шинжтэй хөрөнгө бүртгэсэн	1	18.3								1	18.3	
Дүн			3	65.5							3	65.5		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Хайрхан сумын ЗДТГ	Шилэн дансны цахим хуудсанд 19 мэдээлэл хугацаа хоцроосон, 306.8 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй байна.	1	306.8							1	306.8		
Дүн			1	306.8							1	306.8		
Нийт дүн			4	372.3							1	306.8	3	65.5